

Монгол Улсын Азийн бодлого: Үл нэгдэх, прагматик¹

Г.Төмөрчулуун *

Яагаад Үл нэгдэх, яагаад прагматик гэж?

“Хүйтэн дайн”-ы үед БНМАУ хэрэг дээрээ, де юре биш, де факто тухайн үеийн цэрэг-улс төрийн байгууллага-Варшавын гэрээний байгууллагын нэг гишүүн байлаа. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд Монголд Зөвлөлтийн цэрэг нийт гурван удаа орж ирсэн байдаг. Эхнийх нь 1921 онд, дараагийнх нь 1936-1937 онд, сүүлчийнх 1967 онд орж ирж байрлажээ. 1987- 1992 онд Оросын 82 мянган цэргийн албан хаагч, холбогдох байлдааны зэвсэг, техникийн хамт Монголоос гарсан байдаг². Зөвлөлтийн цэрэг Монголд орж ирж 25 орчим жил байрласан нь сайн муу аль аль талтай байсан гэж тухайн үед МУ-ын Гадаад яамны сайд асан Ц.Гомбосүрэн бичжээ³.

1992 онд Монгол Улс Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн болсон болж, Эвсэлд үл нэгдэх гадаад бодлого баримтлахаа зарласан билээ. Чингэхдээ, Монгол Улс 1988-1992 оны хооронд ЭҮНХ-ий зочин, ажиглагч, жинхэнэ гишүүн гэсэн гурван статусын шаардлагыг бүрэн биелүүлсэн байдаг. “Монгол Улс Эвсэлд үл нэгдэх бодлого баримтлах нь Монгол, Орос, Хятад гурван улсын эрх ашгийг зохицуулах механизм болох юм. Эвсэлд нэгддэггүй Монгол Улс хоёр хөрштөйгөө харилцахдаа хэвшмэл ямар нэг үзэл суртлыг бус харин Монгол Улсын үндэсний эрх

* Шинжлэх Ухааны доктор (Sc.D), проф

1. Энэхүү өгүүлэлд орсон санаанууд зөвхөн зохиогчийнх бөгөөд тухайн асуудлаар Монгол Улсын ГХЯ-ны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй. 2015 оны 5 дугаар сарын 19-нд ГХЯ-нд болсон уулзалтын үеэр Мьянмарын Холбооны улсын төрийн албан хаагчдад зориулан уншсан лекц /Original title: Mongolia's Asia policy: Pragmatic Non-Alignment/.

2. Монгол цэргийн түүхэн товчоон. 496 дугаар тал.

3. “Алтан аргамж” сэтгүүл 2015 он, № 7, 27 дугаар тал.

ашгийг дээдэлсэн объектив хүчин зүйлсийг удирдлага болгох юм гэж тухан үед бичиж байв⁴. ЭҮНХ-ий гишүүн болох асуудал шулуун дардан замаар яваагүй юм. ЭҮНХ-ийн ажиглагч болох үед Оман, Сингапур, Югослав⁵ гурав Монголд Зөвлөлтийн цэрэг байгаа нь ЭҮНХ-ий гишүүний статуст харшилж байна гэх зэргээр сөрөг байр суурьтай байсан юм. Тухайн үед ЗХУ-ын Азийн асуудал хариуцсан орлогч сайд Михайл Степанович Капица ЗХУ дахь Монголын ЭСЯ-нд болсон нэг хүлээн авалтын үеэр намайг дуудаж “Та Монголыг ЭҮНХ-ий гишүүн болгох гээд зүтгээд байгаа гэл үү?. Та их буруу сэтгэж байна. Монголын тусгаар тогтнолд аюул учирвал таны тэр ЭҮНХ танд туслахгүй, харин ЗХУ бол туслана. Иймд та наад үзэл бодлооо өөрчилсөн дээр” гэж байв. Ийнхүү Капица сайдад загнуулсан минь тухайн үед манай яамны нэгдүгээр орлогч сайд асан Др.Ж.Чойнхор, тэр үед ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан байсан Др. Балдоо бид гурав Ломоносовын нэрэмжит Москвагийн Их сургуулийн урилгаар Азийн аюулгүй байдлын тухай олон улсын бага хуралд Москвад оролцох үеэр Монголын ЭСЯ-наас зохион байгуулсан нэгэн хүлээн авалтын үеэр болсон юм. Түүнд ЗХУ-ын ГЯЯ-ны Монголыг хариуцсан орлогч сайд гэдэг утгаараа М.С.Капица уригдсан байсан. Энэ тухай ингэж нуршихын учир Монголын Гадаад яамны нэг газрын зөвлөх ямар асуудал дээр ажиллаж байгааг тэр том улсын Гадаад яамны орлогч сайд мэдэж байсан нь гайхалтай. Монгол ЭҮНХ-нд элсэхэд Зөвлөлтийн ГЯЯ дургүй байна гэдгийг Гадаад яамандаа очиж хэлэж гэж надад тийм зүйл ярьсан байх л гэж одоо боддог юм. Ер нь Зөвлөлтийн удирдлага Монголыг ЭҮНХ-нд ойртуулахын эсрэг байсан нь дээр үеэс эхтэй юм билээ. Далаад онд М.Дүгэрсүрэн сайд Женевт Элчин сайдаар ажиллаж байхдаа энэ асуудлаар эхний алхам хийх гэсэн боловч зөвлөлтийн тал эрс эсэргүүцж байсан гэж МУИС-ийн ОУХС-д зөвлөхөөр ажиллаж байхдаа надад ярьж байж билээ. Гэхдээ энэ асуудлаар “ах нар” бүгдээрээ ийм байр суурьтай байсан гэж хэлж байгаа юм биш. Зөвлөлтийн Дипломат Академид суралцаж байхад миний багш Геннадий Георгиевич Кадымов “ Эвсэлд үл нэгдэх бодлогын асуудал танай улсын гадаад бодлогод чухал байр эзлэх нь

4. Тумурчулуун Г. Политика МНР в отношении Движения Неприсоединения 1961-1990 гг. Диссертация на соискание ученой степени к-и-н. 1990 г. Дипломатическая Академия МИД СССР, стр 35.

5. Гадаад харилцааны төв архив, Монгол ба ЭҮНХ, 1989 он, файл 25-29

байна шүү. Иймд та наад ажлаа ул суурьтай хийх хэрэгтэй” гэж надад зөвлөж, урам өгч байв.

Одоо Үл нэгдэх гадаад бодлого гэж юуг хэлж байгаа талаар хэдэн зүйл хэлье. Юуны өмнө цэрэг-улс төрийн алив эвсэлд нэгдэхгүй, түүний гишүүн болохгүй гэсэн санаа. Хоёрдугаарт, нутагтаа гадаадын цэрэг, цэргийн бааз байрлуулж болохгүй гэсэн үг юм⁶.

Үл нэгдэх бодлого бол Монголын хувьд хөрш хоёр оронтой тэнцвэр барих, сэтгэл зүйн нэг тулгуур болж буй. Монгол Улсын гадаад бодлогын анхны үзэл баримтлалд хоёр хөршийнхөө аль нэгтэй цэрэг-улс төрийн холбоотны харилцаанд орж, нөгөө хөршийнхөө эсрэг эвсэхгүй байх, эсвэл бусад улстай тийм холбоонд орж хоёр хөршийнхөө эсрэг эвсэхгүй байхыг хэлэхээр оруулсан⁷.

Гэхдээ Үл нэгдэх бодлого дан ганц цэрэг-улс төрийн эвсэл холбоонд нэгдэх, нэгдэхгүй тухай асуудал биш юм. Үл нэгдэх бодлого гэдэг нь өргөн утгаараа олон улсын хамтын нийгэмлэгтэй улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн өргөн харилцаатай байхыг хэлнэ. Үл нэгдэх бодлого гэдэг нь олон улсын хамтын ажиллагааг дэмжиж, НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчимд үнэнч байхыг хэлнэ⁸.

Одоо прагматик байна гэсэн санаагаа тайлбарлая. Энэ бол юуны өмнө авах, гээхийн ухаан мөн. Монгол Улсын үндэсний эрх ашгийг юун түрүүн бодолцох ёстой гэсэн санаа. Гадаад бодлогын асуудалд догматик маягаар хандаж болохгүй. Мөнхийн үзэл суртал гэж байхгүй. Үндэсний эрх ашиг шаардвал үзэл суртлыг байнга халж, сольж өөрчилж байх шаардлагатай⁹.

Хэрэв улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд аюул занал учирвал үл нэгдэх бодлогоос таггалзах шаардлагатай. Учир нь ямар ч улс том, жижиг, хүчтэй, хүчгүй, тусгаар тогтнолын хувьд үл нэгдэх бодлого явуулна гэж байхгүй. Энэ нөхцөлд эсэргээрээ эвсэлд нэгдэх бодлого явуулах ёстой юм¹⁰. Үүнийг прагматик байх гэж хэлж байгаа юм.

6. Г.Төмөрчулуун. Даяар ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа, УБ, 2009 он, 82-83 дугаар тал

7. Г.Төмөрчулуун. Олон улсын харилцаа, Монголын гадаад бодлого: онол, практик., УБ, 2015 он, 100-101 дүгээр тал

8. ЭҮНХ буюу The Non Aligned Movement, 2012 онд 120 гишүүнтэй байв.

9. Г.Төмөрчулуун. Даяар ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа, Прагматизм: 1990-ээд оны Монголын гадаад бодлогын үндэс., 2009 он, 78-81 дүгээр тал.

10. Англи эх дээрээ “ No nation is non - aligned with regard to its independence, sovereignty and territorial integrity” гэсэн байгаа.

Аливаа гадаад бодлого өөрөө туйлын зорилго бус, харин тодорхой зорилгод хүрэх арга мөн. Тэр тодорхой зорилго гэдэг бол үндэсний эрх ашиг юм. Монголын үндэсний эрх ашиг нь хоорондоо нягт уялдаатай гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдал
- Үндэсний хөгжил
- Үндэсний сэргэн мандал

Үндэсний эрх ашгаа хамгаалахын тулд дипломат үйл ажиллагаа профессор Х.Моргентаугийн хэлснээр дөрвөн зорилтыг шийдвэрлэх ёстой. Эхлээд монголчууд бид өөрсдөө хэн бэ гэдгээ нарийн тодорхойлох ёстой. Үүнд түүх, соёл, шашны уламжлал, газар зүй, цаг уур, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн байдал, геополитикийн онцлог, гадаад хүрээлэлтэйгээ хэрхэн яаж харьцаж ирсэн, одоо яаж харьцаж байгаа зэрэг цогц асуудал орно. Дараа нь харьцах улсаа буюу олон улсын байгууллагаа үүх түүхээс нь аваад өнөөг хүртэл сайн мэдэх ёстой. Гол нь тухайн улс юуг хүсэж эрмэлзэж, ямар санаа зорилго, сонирхолтойг мэдэх нь чухал. Гуравт, Монгол улс, тухайн улс хоёрын хүсэл эрмэлзэл, сонирхол юунд нийцэж, юугаараа зөрж байгааг олж тогтоох ёстой. Хамгийн сүүлд уг сонирхлын нийцэл, зөрөлдөөнд үндэслэн өөрийн бодлогыг тодорхойлно.

Бодлого, чиг шугамаа ийнхүү тодорхойлсны дараа түүнийг хэрэгжүүлэх бодлогын хувилбарыг олох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энд гадаад бодлогын боломжийн хувилбаруудын тухай яригдаж байна. Нэгэнт тодорхойлсон зорилгоо чухам гадаад бодлогын ямар хувилбараар хэрэгжүүлэх вэ? гэдэг хэд хэдэн хувилбарыг авч үзье.

Томас Хоббс хэлэхдээ хүн хүндээ чоно байдаг гэдэг зарчим олон улсын харилцаанд ч үйлчилдэг гэсэн нь буй¹¹. Конрад Лоренц, хүн бүр эхээс төрөхдөө түрэмгий шинжийг өөртөө шингээсэн байдаг¹². Иймд тодорхой хүмүүсээр удирдуулдаг улс орнууд хоорондоо дайсагнаж, бие биенийгээ түрэмгийлж байдаг гэжээ.

11. Samuel Kim, *The Lorenzian Theory of Aggression and Peace Research, A Critique The War System. An Interdisciplinary Approach*, p.82. Westview Press/Boulder, Colorado, 1980.

12. *Why People Fight in the Causes and Prevention of War* by Seymour Brown. St.Martin's Press, New York, 1987, pp.9-10.

Кеннет Вольцынхоор бол дэлхийн хаан, дэлхийн засгийн газар гэж байдаггүй. Иймд олон улсын харилцаа анархи байдалтай байх тул ертөнцөд дайн дажин тасрахгүй гэсэн нь буй¹³. Эндээс үүдэн улс орнууд гагцхүү өөрийгөө л бодох ёстой гэсэн үзэл газар авч, түүнийг Английн улс төрийн зүтгэлтэн Лорд Пальмерстон тун онож дүгнэсэн байдаг. “Англи улсад мөнхийн дайсан ч байхгүй, мөнхийн анд ч байхгүй. Гагцхүү түүнд мөнхийн эрх ашиг л бий” гэж тэр хэлжээ¹⁴. Энэ томъёоллыг Америкийн реалист сургуулийн эцэг гэгддэг Ханс Моргентау гүнзгийрүүлж “Америкийн гадаад бодлого цорын ганц бурхантай. Тэр бол Америкийн эрх ашиг мөн” гэжээ. Орчин үеийн олон улсын эрх зүйн эцэг гэгддэг Уго Гроций улс хоорондын харилцаанд гагцхүү хуулийг дээдлэх ёстой гэж үзэж байсан бол Германы аугаа их гүн ухаантан Имануэль Кант “олон улсын харилцаанд хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг удирдлага болгох ёстой бөгөөд дэлхийн улс орнууд хоорондоо мөнхийн энх тайван”-ы гэрээ байгуулах хэрэгтэй гэж үзэж байжээ. Өөрөөр хэлбэл, хүчээр түрий барих бодлогын төлөөлөгчид буюу /Хоббс, Пальмерстон, Бисмарк, Талейран, Черчилль, Вольц, Моргентау, Жорж Кенан, Хэнри, Киссенжер, Збигнев Бжежинский/ реалист үзлийг олон улсын эрх зүйг дээдлэхийг уриалагчид буюу Уго Гроций, Стэнли Хоффман хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг шүтэхийг уриалагчид /Кант/ буюу либерал сургууль гэсэн гурван үндсэн номлол Өрнөдөд үүсэж өнөөг хүртэл хөгжиж иржээ. /Зарим судлаачид сүүлийн хоёр сургуулийг нэг номлол хэмээн идеалист номлол гэж хамт нь нэрэлдэг/. Өнөөдрийн байдлаар сүүлийн хоёр сургууль нь давамгайлах байдалтай байна. Энэ нь олон улсын хамтын нийгэмлэгийн дунд хууль сахиулах үндсэн үүрэг хүлээсэн НҮБ-ын үүрэг роль нэмэгдэж буй, ардчилал, хүний эрх, эрх чөлөө зэрэг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг дээдлэх хандлага улам бүр эрч хүчээ авч байгаагаар илэрч байна. Энэ утгаараа бидний дэлхий ертөнц аажмаар Гроций-Кантын дэлхий ертөнц болох нь ээ гэж ойлгогдож байна. Гадаад, дотоод бодлогын асуудал тусгагдсан байдлаас нь авч үзвэл манай шинэ үндсэн хууль ч Гроций-Кантын Үндсэн хууль гэхэд хилсдэхгүй.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын төсөл ч ерөнхийдөө Гроций-Кантын үзэл баримтлал юм. Товчоор хэлбэл

13. Hedley Bull, *The Anarchical Society: A study of Order in World Politics* [London, Macwillian, 1977] p.89.

14. Lord Palmerston, *In The Debate on the Treaty of Adrianople*, Harvard, 3-rd Series, Vol.Col.122.

реалист сургуулийнхны хувьд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал бол хамгийн эрхэм зүйл байдаг. Иймд эдийн засгийн аливаа үйл ажиллагаа тусгаар тогтнодоо хамгаалах гэсэн туйлын зорилгод захирагдах ёстой гэж үздэг. Дотоодын зах, зээлээ хамгаалах, импортын барааны татварыг нэмэх, худалдааны блокууд байгуулах зэрэг бодлого үүнд хамаарна. АНУ, ЕЭЗХН-ийн орнуудын хоорондын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний талаархи зөрөлдөөн ч энэ онолын практик илрэл юм. Харин либерал сургуулийхан /Адам Смитийн талынхан/ тусгаар тогтнол гэсэн улс төрийн зорилгыг бус, ард түмний сайн сайхан амьдарлыг дээшлүүлэх гэсэн эдийн засгийн зорилтыг гол болгодог либерал эдийн засагчдын хувьд төр, эдийн засгийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаар гэх мэтийн ойлголт байдаггүй. Бүх зүйл эдийн засгийн хуулиар шийдэгдэнэ гэж үздэг. Иймд тэдний хувьд бие даасан улс гэдэг ойлголт байдаггүй. Учир нь тэд дэлхийг бие даасан улсуудын нийлбэр гэхээсээ эдийн засгийн нэг цогц орон зай гэж үзэж бараа, үйлчилгээ, хүмүүсийг чөлөөтэй солилцох ёстой гэдэг.

Монгол шиг жижиг улсын хувьд хоёр онолын аль аль нь сайн, муу хоёр талтай. Реалист сургуулийн онолоор явбал зожигрох, ганцаардах аюулд орж мэднэ. Либерал онолоор явъя гэвэл бусдын нөлөөнд хэт орох аюул байна. Ухаалаг бодлого энэ хоёрын зааг дээр буюу зөв хослуулах, өөрөр хэлбэл прагматик бодлогод л байгаа болов уу. Тэгэхдээ ертөнцийн хөгжлийн хэтийн төлөв либерал онолын талд буйг үргэлж бодох нь зөв.

Дээрхээс үзвэл улс төрийн бодлогод ч, эдийн засгийн гадаад харилцааны бодлогод ч реалист, либерал хоёр сургуулийг зөв хослуулж прагматик хандах нь Монголын хувьд онц чухал бөгөөд ийм практик чиг баримжаа “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх”¹⁵ тухай Үндсэн хуулийн заалтад нийцэх юм.

15. Энэ гурван номлолын тухай харьцуулсан, хамгийн тодорхой ойлголтыг Роберт Гилпиний номоос үзэж болно.